



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл
2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООДЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-29

1.Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч-4 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2026.03.20-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/ 5-23

2.Монгол Улс, Холбооны бүгд найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2026.03.27-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/ 23-29

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хороодын
4 дүгээр сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 58 гишүүнээс 30 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 05 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Бум-Очир, Х.Жангабыл;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Т.Аубакир, Д.Батбаяр, Ж.Батсуурь, Г.Ганбаатар,
Л.Гантөмөр;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Ж.Баясгалан, Х.Болормаа,
Ж.Ганбаатар;

Тасалсан: Э.Бат-Амгалан, Л.Оюун-Эрдэнэ.

**Нэг.Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк
хоорондын “Эрчим хүч-4 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн
газар 2026.03.20-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анар, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Д.Ариунтуул, Өрийн удирдлагын газрын дарга Л.Гантогтох, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга И.Лувсанцэрэн, мөн газрын Эх үүсвэр төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Дашдаваа, мөн компанийн Судалгаа, хөгжил, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Лхагвадэмбэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, референт Б.Гандиймаа, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд З.Мэндсайхан, хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос

гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр, Д.Ганбат, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Өрийн удирдлагын газрын дарга Л.Гантогтох нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, П.Наранбаяр, П.Сайнзориг, Г.Тэмүүлэн, Д.Ганбат, С.Эрдэнэболд, Б.Мөнхсоёл нар үг хэлэв.

Н.Наранбаатар: Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч-4 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	17
Татгалзсан:	14
Бүгд:	31

54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг, П.Наранбаяр, Б.Энхбаяр, Х.Булгантуяа нарыг дэмжсэнээр тооцож, 67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 15 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улс, Холбооны бүгд найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2026.03.27-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анар, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Д.Ариунтуул, Өрийн удирдлагын газрын дарга Л.Гантогтох, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга И.Лувсанцэрэн, мөн газрын Эх үүсвэр төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Дашдаваа, мөн компанийн Судалгаа, хөгжил, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Лхагвадэмбэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, референт Б.Гандиймаа,

Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд З.Мэндсайхан, хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан, Д.Ганбат, Р.Батболд нарын тавьсан асуултад Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Өрийн удирдлагын газрын дарга Л.Гантогтох нар хариулж, тайлбар хийв.

Н.Наранбаатар: Монгол Улс, Холбооны бүгд найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 14
Бүгд: 32
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг, Ж.Энхбаяр нарыг дэмжсэнээр тооцож, 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 15 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 25 минут үргэлжилж, 58 гишүүнээс 44 гишүүн хүрэлцэн ирж, 75.9 хувийн ирцтэйгээр 15 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 14 цаг 05 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Байнгын хорооны хороодын эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Байнгын хороодын хамтарсан хуралдааны ирц бүрдсэн тул 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Гишүүдийн ирцийг танилцуулъя. Ирц 50.9 хувьтай байна. Ирсэн гишүүдийг дуудаж танилцуулъя. Загджавын Мэндсайхан, Ганбатын Очирбат, Ганзоригийн Тэмүүлэн, Өлзийхүүгийн Шижир, Лутаагийн Энхнасан, Жигжидийн Батжаргал, Пүрэвжавын Ганзориг, Баатаржавын Мөнхсоёл, Чинбатын Номин, Цагаанхүүгийн Мөнхбат, Буяагийн Тулга, Ганбатын Хосбаяр, Баттөмөрийн Энхбаяр, Дашцэрэнгийн Энхтүвшин, Жадамбаагийн Баясгалан, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Пүрэвбаатарын Мөнхтулга, Пүрэвжавын Сайнзориг, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Дамдины Цогтбаатар, Жадамбын Энхбаяр, Ренчиндоржийн Батболд, Хүрэлбаатарын Булгантуяа, Батжаргалын Заяабал, Нанзадын Наранбаатар гэсэн гишүүд ирсэн байна аа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал. 2 асуудал байна.

1.Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч-4 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2026.03.20-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

2.Монгол Улс, Холбооны бүгд найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2026.03.27-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улс, Олон Улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын Эрчим хүч-4 төсөлд төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Мэндсайхан Сангийн сайд, Анар Сангийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Дэлгэржаргал тус яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Гантогтох тус яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн

удирдлагын хэлтсийн дарга, Ганзориг Тус яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Ариунтуул тус яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, ЭХЯ-аас Найдалаа эрчим хүчний сайд, Ерэн-Өлзий тус яамны ТНБД, Хуягцогт Тус яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лувсанцэрэн Тус яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Энхтүвшин тус яамны Бодлого төлөвлөлтийн газрын Эх үүсвэр төлөвлөлтийн хэлтсийн дарга, Дашдаваа Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨК-ийн гүйцэтгэх захирал, Лхагвадэмбэрэл Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Судалгаа, хөгжил, төлөвлөлтийн хэлтсийн дарга. Ажлын хэсгийг танилцууллаа.

Монгол Улс, Олон Улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын Эрчим хүч-4 төслийн зээлийн хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна аа. Мэндсайхан сайдыг урьж байна. Микрофоныг нээе.

З.Мэндсайхан: Аюулгүй байдлын байнгын хорооны дарга, Төсвийн байнгын хорооны дарга болон Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Эрчим хүч-4 төсөл буюу Мандалговь, Арвайхээрийн чиглэлийн 220квт-ын 2 хэлхээт 287км урт Цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАГШ/ дэд станцыг өргөтгөх төсөл нь шинэ сэргэлтийн бодлого Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан өндөр ач холбогдолтой төсөл бөгөөд Засгийн газраас уг төслийг Олон улсын сэргээн босголт хөгжлийн банкны эх үүсвэрээс санхүү хэрэгжүүлэхээр зээлийн хэлэлцээрийг хийгээд байна аа.

Энэхүү төслийг Олон улсын Сэргээн босголт хөгжлийн банкнаас олгох 78 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бөгөөд зээлийн хугацаа 25 жил, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 5 жил бөгөөд баталгаат Овернайт санхүүжилтийн хүү дээр 1.4 хувийн нэмэгдэлтэй хувьсахгүй байна аа. Тус зээлийн хэлэлцээр нь олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Монгол Улсын Их Хурлаар заавал соёрхон батлагдах гэрээ бөгөөд Өрийн удирдлагын тухай хуулийн 24.3-д заасны дагуу зээлийн хөрөнгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр ЦДҮС ТӨХК-д дамжуулан зээлдүүлэхээр төлөвлөсөн. Төслийн хүрээнд Мандалговь Арвайхээр чиглэлийн 287км урттай 220квт-ын-ын ЦДАШ болон Өвөрхангай дэд станцыг шинээр барих, Баянхонгор, Арвайхээр, Мандалговь дэд станцуудыг өргөтгөх ажлууд хийгдэх бөгөөд төслийг хэрэгжүүлснээр бүс нутгийн 50 мянга гаруй хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагаа дээшилж хангайн болон баруун бүсийн аймгуудад төлөвлөж буй хөгжлийн хөтөлбөрүүдийг эрчим хүчний хангамжаар бүрэн хангах боломж бүрдүүлэх ач холбогдолтой юм аа.

Иймд Монгол Улс, Олон улсын Сэргээн босголт хөгжлийн банк хоорондын Эрчим хүч-4 төсөл зээлийн хэлэлцээрийг хэлэлцэн дэмжихийг хүсье ээ. Баярлалаа.

Н.Наранбаатар: Мэндсайхан сайдад баярлалаа. Зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Очирбат танилцуулна аа. Очирбат гишүүнийг урьж байна.

Г.Очирбат: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улс, Олон улсын Сэргээн босголт хөгжлийн банк хоорондын Эрчим хүч-4 төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаараа дээрх хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Эрчим хүч-4 төсөл буюу Мандалговь, Арвайхээр чиглэлийн 220квт-ын 2 хэлхээт 287км урт ЦДАШ дэд станцыг өргөтгөх төсөл нь шинэ сэргэлтийн бодлого Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан өндөр ач холбогдолтой төсөл бөгөөд Засгийн газраас тус төслийг Олон улсын сэргээн босголт хөгжлийн банкнаас олгох 78 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхдээ Өрийн удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-д заасны дагуу зээлийн хөрөнгийн эргэн төлөгдөн төлөгдөх нөхцөлтэйгөөр ЦДҮС ТӨХК-д дамжуулан зээлдүүлэхээр төлөвлөсөн байна аа.

Тус зээлийн хугацаа 25 жил, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 5 жил, баталгаатай овер найт санхүүжилтийн хүү софер дээр нэмэх нь 1.4 хувийн нэмэгдэлтэй хувьсах хүүтэй байх бөгөөд зээлийн хэлэлцээрийг олон улсын гэрээний дагуу, хуулийн дагуу Монгол Улсын Их Хурлаар соёрхон батална аа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд Мандалговь болон Арвайхээрт зөвхөн ЦДАШ сүлжээ барих нь хангалтгүй ДЦС барихаар төлөвлөж байгаа эсэх талаар* Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга 78 сая ам.долларын зээл нь зээлийн таазад нөлөөлөх эсэх төслийн шалгуурын талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг зээлийн хөрөнгөөр дулаан цахилгааны эх үүсвэр барихаас илүүтэйгээр цахилгаан дамжуулах шугам барихаар төлөвлөсөн нь яагаад илүү оновчтой гэж үзсэн, мөн эрчим хүчний салбарт одоо мөрдөгдөж байгаа тарифаа нэмэгдүүлэхгүйгээр зээлийн эргэн төлөлтийг бүрэн төлөх боломжтой эсэх, тариф нэмэгдүүлэхтэй холбоотой тооцоолол байгаа эсэх талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Мандхай тус төслийг яагаад Мандалговиор дамжуулах болсон, Улаанбаатараас дамжуулах боломжийг судалсан эсэх төсөл хугацаандаа хэрэгжихгүй байх, төслийн зардал өсөх, төсөвт дарамт үүсэх зэрэг эрсдэлүүдийн талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа эрчим мөчний салбарт хэрэгжиж байгаа төслүүд гадаадын зээл тусламжийн хэдэн хувийг эзэлж байгаа юм. Эргэн төлөлт төлөвлөгөөний дагуу төлөгдөж байгаа эсэх, ЭХЯ-ны цаашид яам нь цаашид салбартаа тулгамдаад байгаа асуудлыг ямар арга хэмжээ авах талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа Эрчим хүч-4 төсөл буюу Мандалговь, Арвайхээр чиглэлийн ЦДАШ дэд бүтцийг өргөтгөх төсөл нь улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан боловч хугацаа алдаж 2026 онд зээлийн хэлэлцээр орж ирж байгаа талаар, төслийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх боломжтой эсэх, улсын төсвөөс нэмэлт зардал гаргах эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд төслийн төсөвт өртөг өндөр байгааг хэрэгжүүлэх явцад анхаарч бууруулах талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг бага хүүтэй боломжийн нөхцөлтэй тус зээлийг дэмжиж байгаа бөгөөд цаашид зээлийн хөрөнгөөр дулаан цахилгааны эх үүсвэрийг барих асуудалд

анхаарах зүйтэй талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан Олон улсын сэргээн босголт хөгжлийн банкнаас олгож буй энэхүү зээл нь нэн хөнгөлөлттэй хамгийн таатай нөхцөлтэйгөөр талаар тус тус саналаа хэлсэн болно оо.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улс Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын эрчим хүч 4 төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 59.1 хувийн саналаар зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж гэсэн байна.

Н.Наранбаатар: Очирбат гишүүнд баярлалаа.

Одоо Зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Тэмүүлэн гишүүнээр тасаллаа. Хосбаяр гишүүн асуулт асууна.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Энэ төслийг, энэ зээлийн хэлэлцээрийг дэмжиж байгаа. Манай хангайн бүс нутаг буюу Архангай аймаг, Баянхонгор аймаг, Өвөрхангай аймаг бол 300 мянган хүн амтай. Эрчим хүчний найдвартай байдал нэлээн алдагдсан ийм бүс нутаг. Яагаад вэ гэхээр зэрэг Эрдэнэт Булганаас ЦДАШ-аар эрчим хүчээ авдаг. Тэгээд та бүхэн санаж байгаа бол хэдэн жилийн өмнө Булган аймагт нэг зун бороо ороод усан шуурга болоход Булган аймагт нэг хэдэн өндөр хүчдэлийн шон унахад энэ бүс нутгийн ард иргэд 7 хоног тоггүй байсан. Эндээс юу харагдаж байна вэ гэхтэйгээ зэрэг эрчим хүчний найдвартай байдал алдагдсан байна гэдэг нь харагдаж байгаа.

Тийм учраас энэ Мандалговь, Арвайхээр чиглэлийн 220-ийн хос энэ агаарын цахилгаан дамжуулах шугамын энэ төсөл хийгдэж энэ шугам тавигдсанаар энэ бүс нутгийн иргэдийн цахилгаан хангамжийн найдвартай байдал нэмэгдэх юм аа.

Дээр нь Монгол Улсын эрчим хүчний гол эх үүсвэрүүд энэ Төв аймаг буюу энэ Баян сум, Бөөрөлжүүт, Багануур гээд энд баригдаж байгаа учраас энэ бүс нутагт бий болсон үйлдвэрлэгдэж байгаа ирээдүйд бий болох энэ эрчим хүчний эх үүсвэрийг тэр Хангайн бүс нутагт хүргэх энэ дамжуулах шугам чухал ач холбогдолтой гэж бодож байгаа. Тийм учраас энэ төслийг дэмжиж байгаа.

Тэгээд ЭХЯ-ныхнаас асуухад энэ төслийн яг ТЭЗҮ зураг төсөл яг эцсийн байдлаар бэлэн болсон уу? Яг ашиглалтад орох хугацаа нь хэзээ вэ? Яг одоо энэ хэлэлцээр ингээд Их Хурлаар бид нар ингээд дэмжээд батлагдсан нөхцөлд энэ жилдээ ажил эхлэх үү? Тэгээд яг одоо хэдэн онд дуусах вэ? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч гэж ингэж хүсэж байна.

Н.Наранбаатар: Хариулъя энэ ЭХЯ. Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг нээе. Нэр албан тушаалаа хэлээд хариулна.

Б.Ерэн-Өлзий: ЭХЯ-ны ТНБД Ерэн-Өлзий Хосбаяр гишүүний асуултад хариулъя.

Мандалговь, Арвайхээрийн 220 киловольтын шугам Арвайхээр 220 вольтын дэд станцын төслийн зээлийн хэлэлцээр Улсын Их Хурлаар ингээд эцэслэн батлагдчихвал Дэлхийн банктай хамтраад бид нар төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ингээд ажил руугаа орно оо. Өмнөх энэ олон улсын банкнуудтай хамтран хэрэгжүүлж байгаа энэ томоохон төслүүд дээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад хамгийн богинодоо нэг хагас жил уртдаа 10 сарын шахуу ийм хугацаа яг бодитоор ордог. Энэ дээр банкнууд бол зөвхөн өөрсдөө ажиллахаас гадна өөрсдийгөө сонгосон ийм худалдан авалтын тендер агентуудыг давхар ажиллуулаад явдаг болохоор нэлээн тийм сонгон шалгаруулалтын ажил удаашралтай явдаг юм аа.

Тэгэхээр одоо 2026 оны сүүлээр амжаад гэрээ байгуулчихвал барилга угсралтын ажил бол нэг жил хагасын хугацаанд үргэлжлээд дуусахаар байна. Тэгэхээр 2027 оны сүүл гэхэд ер нь бол ашиглалтад 2028 оны эхээр хавар ашиглалтад орохоор ийм цаг хугацааны график харагдаж байна аа.

Н.Наранбаатар: Хосбаяр гишүүн тодруулъя.

Г.Хосбаяр: Одоо нөгөө бидэнд өмнө нь нэг муу түүх байгаа шүү дээ. Нөгөө 10 аймгийн дулааны станц гээд Солонгосын Эксим банкны зээлээр хийгдэж байгаа ажил. Тэгээд энэ дээр одоо мөн л нөгөө гадна талд гүйцэтгэгч шалгаруулсан учраас нөгөө бүтэлгүй гүйцэтгэгч орж ирээд ажил ингээд дампуурчихсан. Тэрэн шиг ингээд Дэлхийн банк маань 2 үе шаттай тендер зарлагдана. Тендер шалгаруулалтын процесс нь 10 сар үргэлжилнэ гэж байна. Тэгээд яг дотоодын ААН оролцох боломжтой юу? Тэр боломж нь нээлттэй байгаа юу? Тэгээд ер нь одоо энэ яг тендер шалгаруулалт худалдан авалт дээр энэ мэргэжлийн яам танайх ер нь бас ямар оролцоотой байдаг юм бэ? Тэр санал бодлоо хэлэх тендерийн комисс нь орох ч гэдэг юм уу ийм тэр худалдан авалт дээр оролцох тийм нөлөөлөл юу байгаа юу? Яг танай яамнаас.

Н.Наранбаатар: ЭХЯ хариулъя. 2 дугаар микрофон.

Б.Ерэн-Өлзий: Ерэн-Өлзий гишүүний асуултад хариулъя.

Худалдан авалт бол Дэлхийн банкны худалдан авалтын дүрэм журмаар явна. Өмнөх 10 аймгийн төслийн Солонгосын зээлээс онцлог нэг байдал нь болохоор Солонгосын зээл бол зөвхөн Солонгосын гүйцэтгэгч компани байна гэсэн угаасаа зээлийн нөхцөлтэй. Дэлхийн банкны энэ олон улсын нээлттэй тендер байна. Энд дотоодын болон гаднын ямар ч компани оролцож болно. Ямар нэг улс юм уу юу гэдэг юм технологи гарал үүсэл энэ дээр шаардах юм байхгүй.

Тэгэхээр энэ Монголын компаниуд олон улсын компаниудтай хамтраад хамтарсан консорциум эд нар бар болоод оролцоно. Санхүүжилтийн шаардлагыг хангаж байвал бас дотоодын компаниуд ч гэсэн бие даагаад эсвэл хоорондоо нийлээд ингээд оролцох бүрэн боломжтой байгаа.

Дэлхийн банкны худалдан авалтын дүрмээр энэ сонгон шалгаруулалт явна аа.

Н.Наранбаатар: Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Ер нь манайд бол эрчим хүчний асуудал, эрчим хүчний дамжуулах шугам энэ тэр бол үнэхээр шаардлагатай энийг хийх нэн тэргүүний ийм зорилго байна л даа. Яаж ийгээд л хийх нь л зөв байх. Тэгээд дэмжиж байна. Гэхдээ энэ зээлүүд маань ямар болчхоод байна аа. Нийтдээ Монгол Улсын зээл чинь 40 тэрбум гараад явчихсан байна уу? Тэр дотроо нэг хэдхэн жилийн өмнө Засгийн газрын зээл чинь 6, 7 тэрбум байсан. Одоо 10 гараад явчихсан уу? Ингээд зээл аваад байдаг, аваад байдаг. Тэрнийх нь үр дүн энэ ашиглалт хариуцлага энэ юмыг ярихаар энэ Улсын Их Хурал дээр ерөөсөө явдаггүй. Үндэсний аюулгүй байдлын хэмжээнд оччихлоо л доо.

Тэгээд авлига хулгай нь гаараад байдаг хажуугаар нь. Түрүүний гишүүд ярьж байх шиг байна. Одоо дулааны станц байх ёстой. Тэр Эксим банкны. Арваад жилийн өмнө л эхэлсэн шүү дээ. Одоо тэр хаана явна вэ? Нэг салан баавгайн үлгэрээр өмнөх авсан юмаа аваад л хариуцлагагүй юм хийчхээд л дараагийн зээлийг аваад л ингээд яваад байдаг. Уул нь нөөц бололцоогоо ингээд үзэх юм бол бид нар чинь зээл авахаар биш зээл өгөхөөр орон л доо. Энэ Харбины гэрээг хар. Өчнөөн тэрбумын алдагдалтай, цаана нь маш их хулгайтай. Араас нь бид нар хариуцлага ярьж чаддаггүй. Төмөр замын холболтыг хар. Эхнээсээ ямар байлаа? Танк орж ирнэ гэж айлгадаг байсан. Тэгээд одоо бас юу билээ хилээ хаана гэх шиг.

Нэг иймэрхүү л юм ярьдаг Засгийн газрын гишүүдтэй, ийм л улс орон болчхоод байгаа юм л даа. Бас энэ зээл авахгүй бас ямар нэгэн юм хаах уу боох уу? Бас тийм юм байгаа юу үгүй юу?

Тэгэхээр нөгөө улс орон нь шал өөр юм яриад байгаа л даа. 15 жилийн өмнө л арваад жилийн өмнө урд хөршийн Ерөнхийлөгч Си Жин пин айлчлаад ирэхдээ бол энэ экспортоо та нар 20 тэрбумд хүргээрэй л гэсэн 10 жил болж байхад одоо болтол 20 тэрбумд хүргэж чадаагүй л явна л даа. Нэг 18 тэрбумтай. Бид нарын ажил нэг ийм л байгаа юм л даа. Уул нь зээл авах биш энэ байгаа юмаа олигтойхон зараад тэр мөнгийг авлига хулгайгаас нь гадуур аваад ард түмэндээ хэрэгтэй юм хийчихмээр байх юм. Энийг яг эсрэгээр нь л хийгээд байгаа юм л даа. Энийг яаж өөрчлөх вэ? Өөр болох уу, болохгүй юм уу? Ингээд л яваад байх юм уу. Тэгээд юу гэлээ дараа нь энийг чинь манай үр хүүхдүүд төлдөг юм, ард түмэн төлдөг юм. Дандаа нартай өдөр байхгүй л дээ.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? Сангийн сайд хариулах уу? Мэндсайхан сайд.

З.Мэндсайхан: Ганбат гишүүний асуултад хариулъя.

Одоо нийтдээ яах вэ гаднын зээл тусламжаар бол зээлээр 74 төсөл хөтөлбөр хэрэгжээд явж байгаа. Нийтдээ хэлэлцээр хийгдсэн 23.8 их наяд төгрөгийн хэлэлцээр бүхий гадаад зээл байгаа. Эндээс бид нарын ашиглаагүй үлдэгдэл нэг 13.8 их наяд байна. Эрчим хүчний салбарт 2.9 их наядын нийт зээлийн 12.4 хувь эзэлж байгаа. Тэгэхээр энэ өрийн тааз өрийн удирдлагын хуулиар бол ямар нэгэн зөрчил байхгүй ээ. Бид нар чинь ДНБ-ий 60 хувь буюу одоо бол гүйцэтгэл нэг 40 хувьтай явж байгаад цаана нь бид нарт 20 хувийн орон зай байна. Тэр техникийн шинжтэй асуултуудад нь ажлын хэсэг хариулчих байгаа.

Н.Наранбаатар: Ажлын хэсэг нэмж хариулъя. Хэн хариулах вэ? 6 номер ажлын хэсгийн.

О.Гантогтох: Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох. Ганбат гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын өрийн хувьд бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 35.4 их наяд. Үүнээс Засгийн газрын гадаад зээлийн хэмжээ бол 23 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа. Энэхүү зээлүүд бол дэд бүтэц болон эрчим хүчний салбарт ашиглагдахаар энэ төсөл орж ирж байгаа. Энэ маань Засгийн газрын Өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийг өнгөрсөн жил Улсын Их Хурлаас баталсан. Энэ стратегийн баримт бичигт бол шинээр хөнгөлөлттэй болон нэн хөнгөлөлттэй энэ гадаад зээлийн эх үүсвэрийг түлхүү дэд бүтэц эрчим хүчний салбарт түлхүү ашиглахаар заасан. Тэгээд энэ орж ирж байгаа 2 зээлийн төсөл маань стратегийн баримт бичигтэй бүрэн нийцэж байгаа.

Н.Наранбаатар: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Энэ эрчим хүч дулаан дээр өмнө авсан зээлийн ашиглалт төлөлт ямар байгаа вэ? Тэнд хэн хариуцлага явж байгаа вэ гэж би асуусан л даа. Ялангуяа одоо манай Баянхонгор аймаг, Өвөрхангай өөр 10 аймагт барих тэр дулааны станц юу болсон бэ? Хэн нэгэн хариуцлага хүлээж байгаа юу, хүлээхгүй байгаа юу? Тэр мөнгө төгрөг яасан бэ? Зээлийн хүү нь явж байгаа юу? Энэ ирэх онуудад ойрын 2, 3 жилдээ багтаад ямар ямар зээлийн төлөлт байгаа вэ? Бид нар чинь 10 жилийн өмнө л зээлжих зэрэглэлд В хасах В байлуу сая л буцаад тэрэндээ очсон шүү дээ. Ерөөсөө өөдөлж дэвшихгүй л яваад байгаа л даа. Энийг нэг хэлээд өгчихвөл зүгээр байх юм. Тэгээд асуулт асуудаг хариулт хэлдэггүй. Уул нь тэр хууль дээр чинь хариултаа тов тодорхой өгч байх ёстой шүү дээ. Ийм л Улсын Их Хурал болчихоод байгаа юм.

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн 7 хариултаа тов тодорхой өгнө шүү.

Ж.Дэлгэржаргал: Ганбат гишүүний асуултад хариулъя.

Сангийн яам, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар, Дэлгэржаргал. Одоо яг гадаад зээлийн ашиглалт дээр эрчим хүчний салбарт явж байгаа төслүүдийн зээлийн яг хэлэлцээрийн дүн 2.9 их наяд байгаа. Үүнээс 1.7 их наядыг ашиглагдаагүй явж байна гэсэн үг. Тэгэхээр энэ төслүүдийн маань хугацаа бас хэлэлцээрийн хугацаагаараа хамгийн цаад талын төсөл 2030 онд дуусна. Энэ хүртэл бид нар 1.7 их наядыг хэлэлцээрийнхээ хугацаанд ашиглаж дуусах ийм төлөвлөгөөтэй явж байгаа. Ашиглалт нэг 38 хувьтай. 10 аймгийн дулааны станцын төслийн хувьд бол 148 сая ам.доллороос 62 сая ам.долларыг ашигласан. Нийт 10 аймгийнхаа гүйцэтгэлийн хувьд 45 хувьтай. Яг энэ шүүхийн гүйцэтгэгч гүйцэтгэгч компани дампуурсантай холбоотой Солонгосын хуулиар шүүхийн маргаан үүсээд явж байгаа. Одоо энэ асуудал дээр Монголын талаас бид нар бас яг энэ хуулийн зөвлөх үйлчилгээ Эрчим хүчний яам аваад гүйцэтгэлийн баталгааг бол бид нар буцаагаад төвлөрүүлээд авчихсан байгаа. Урьдчилгаа төлбөрийн.

Н.Наранбаатар: Нэмээд тодруулчих, гүйцэд хариул. Хэн хариуцлага хүлээх юм?

Ж.Дэлгэржаргал: Урьдчилгаа төлбөрийн баталгаан дээр байгаа 19 сая ам.долларыг авахаар бас ийм шүүхийн процесс явж байгаа. Хамгийн сүүлд болсон хэлэлцээрээр Солонгосын Эдийн засаг, Сангийн яам, Солонгосын Эксим банк, Монгол талаас Сангийн яам, ЭХЯ хамтарсан уулзалтуудыг хийгээд яг энэ шүүхийн процесс яг эцэслэж шийдэхээр тэр хохирлыг гүйцэтгэгч компани хариуцах уу гэдэг асуудал эцэслэн шийдвэрлэгдэнэ. Энэ хүрээнд бид нар яг Эксим банкнаас зөвлөх үйлчилгээ гаргаад бүх аймгууд дээр яг бодит гүйцэтгэл дутуу ажлуудыг эцэслээд ингээд дүгнэлтээ ЭХЯ-нд ирүүлчихсэн байгаа. Одоо яг явж байгаа процесс бол яг энэ үлдэгдэл санхүүжилтээр бид нар яг энэ төслийг үргэлжлүүлээд дуусгах, дуусахад дутагдаж байгаа эх үүсвэрийг улсын төсвөөс гаргах уу Эксим банк санхүүжилтээр явах уу гэдэг хэлэлцээр бол яг хийгдээд явж байна. Энэ 4 сарын сүүлээр энэ эцсийн шийдвэрүүд бүх ажлын хэсгийн хүрээнд гарахаар байгаа.

Н.Наранбаатар: Тэмүүлэн гишүүн асуулт асууя.

Г.Тэмүүлэн: Би энэ зээлийн хэлэлцээрүүдтэй холбоотойгоор бас нэг ерөнхий зарчмын нэг хэд хэдэн тодруулах зүйлүүд байна. Гадаад зээл тусламж болоод энэ өрийг хязгаарлах бодлоготой холбоотойгоор бас өмнөх парламент буюу 2023 оны 5 сард бид нар бас ядаж энэ зээл тусламжийнхаа төлөвлөлтийг болоод хяналт хариуцлагыг сайжруулах зохицуулалтуудыг бас хийсэн. Энэ хуулийн заалтууд бас яг хэрхэн хэрэгжиж байгаа юм бэ гэдэг талаар асуух нь зөв байх гэж бол бодож байна. Үндсэндээ манай энэ гадаад өр зээл болоод энэ удирдлагыг сайжруулах асуудал чинь нэлээн бас хүндхэн том асуудал болж гарч ирж байна аа. Хэдий өмнөх оны төгсгөлөөр 35.5 их наядын Засгийн газрын гадаад зээлийн өрийн үлдэгдэл байгаа ч гэсэн энэ чинь энэ ондоо нэмэгдэж орж ирж байна. 2026 онд нэрлэсэн үндсэн нэр 51.2 их наяд буюу нийт үндсэндээ ДНБ-ий чинь 43.8 их наяд болох гэж байна аа.

Үндсэндээ Монгол Улсын Засгийн газар нийт өрийнхөө үйлчилгээнийхээ зардал дээр энэ жил 3.7 их наяд буюу улсын төсвийнхөө нийт 10 хувьтай тэнцэх хэмжээний зардлыг төлөх гэж байна. Тэгэхээр бид нар бол яах вэ? Би зүгээр энэ эрчим хүчний төсөлтэй холбоотой асууж байгаа зүйл биш шүү.

Нийтлэгээрээ томоороо, макро эдийн засаг талаасаа бид нар энэ төсөв санхүүгийнхээ бодлого дээр анхаарч харахгүй бол нөхцөл байдал чинь хүндэрч байна шүү. Төсвийнхөө зардлын 10 хувийг бид нар өрийнхөө үйлчилгээний зардалд явуулаад байж мөнгө байна аа. Тэгэхээр энийг ядаж өр зээлээ үе шаттайгаар бууруулах тодорхой зохицуулалтууд, санхүүжилтүүдийг хийх арга хэмжээгээ авахгүй бол үндсэндээ энэ өрийн үлдэгдэл чинь хамгийн том асуудал болж гарч ирж байна. Залгаад наад Засгийн газраас чинь гадна Засгийн газрын бусад өр буюу бонд өрийн баталгаа чинь жил бүр өөрөө өсөж байгаа чинь хамгийн том эрсдэлтэй асуудал болж байна.

2025 онд Засгийн газрын бусад өр чинь 6.4 их наяд байсан. Одоо 2026 онд 10.3 их наяд болж байна. Тэгэхээр энэ бодлого дээрээ чинь энэ Улсын Их Хурал нь ч Улсын Их Хурал шиг, Засгийн газар нь ч, Сангийн яам нь ч энэ асуудлууд дээрээ хариуцлагатай хандахгүй бол улсын төсвийн чинь гадна танай өрийн удирдлагын бодлогын чинь гадна бусад олон зээл бондууд гараад явчихлаа. Макро эдийн засгаа хянаж чадаж байна уу? Энэ асуудлууд дээр өр нь та хэд ямар бодлого баримтлаад байгаа юм бэ? Энэ зээлийнхээ ашиглалтыг сайжруулах асуудлууд дээр ядаж нэг

ийм төлбөрийнхөө тэнцэл дээр дарамт учруулахгүй байх байдлаар энэ асуудлуудаа зохицуулах юмнуудаа хийж байгаа юм уу.

Би яг онцгойлж энэ 2 асуудал дээр яриагүй шүү. Энэ хоёртой маргаан бид нар эрх ашгийн эрэмбээр бол шийдвэрлэх ёстой асуудал. Гэтэл томоороо цаана чинь бусад орон нутаг дээр, нийслэл дээр томоохон төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн асуудлууд энэ чинь өөрөө улсын чинь эдийн засаг төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлөх гэж байгаа асуудлууд болж байна гэдэг асуудал байгаа.

Энэ дээрээ та хэд ер нь яг ямар дүн шинжилгээ хийгээд байгаа юм? Ингээд харсан ч хараагүй юм шиг сонссон ч сонсоогүй юм шиг ийм байдлаар яваад байх юм уу.

2023 оны 5 сард бид нар энэ 2 Байнгын хороо хамтарч энэ асуудал дээр хариуцлагатай ханддаг байх ёстой. Төсвийн байнгын хороо.

Н.Наранбаатар: Гүйцгээе, тодруулъя.

Г.Тэмүүлэн: 2 Байнгын хороо хамтарч хуралдаж энэ асуудлууд дээр хариуцлагатай шийдвэр гаргадаг байя гээд. Дангаараа Аюулгүй байдлын байнгын хороо шийддэг байсан асуудлыг бид нар хамтарч шийддэг болж байгаа юм. Эцэст нь өрийн удирдлага дээр хариуцлага хүлээдэг Төсвийн байнгын хороо энэ дээр хамтарч оролцож дуу хоолойгоо гаргадаг байгаач, хариуцлага хамтарч үүрдэг байгаач гэдэг үүднээс хийсэн юм. Тэгэхээр тэр үед бид нар хийсэн хуулийн дагуу 6.5.5 буюу Өрийн удирдлагын тухай хуулийн 6.5.4 дээр энэ хуульд заасны дагуу улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгаанд хамаарах зээл авах бүрд шүү. Зээлийн гэрээ хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах бүрд нийт зээлийн хэмжээ, эргэн төлөх хуваарь, хүү зээлийн зориулалт, зэргийг тухай бүр олон нийтэд мэдээлнэ гэж хийсэн байгаад байгаа юм. Одоо тэгээд энэ зээлийн хэлэлцээр орж ирж байна.

Та бүхэн Сангийн яамнаас энэ талаараа мэдээллүүдээ олон нийтэд хийсэн юм уу?

Нийт наад улсын чинь зээлийн чинь нийт хэмжээ хэд болоод байгаа юм? Эргэн төлөх хуваарь нь хэд болоод байгаа юм? Нийт зээлийн чинь жигнэсэн дундаж нь хэд болоод байгаа юм? Энэ асуудлууд дээр Сангийн яам тухай бүр оруулж ирсэн асуудал болгон дээр одоо бол олон нийтэд мэдээллээ хийж өгөх ёстой.

Н.Наранбаатар: Хариулъя. Ажлын хэсгийн 6 номерын микрофон.

Л.Гантогтох: Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын өрийн удирдлагын хувьд бол 3 жил тутам Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийг Улсын Их Хурлаас баталж өгч байгаа. Энэ стратегийн баримт бичгийн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа гол арга хэмжээнүүдийн нэг бол яалт ч үгүй энэ өрийн үйлчилгээний дарамтыг бууруулах энэ арга хэмжээ байгаа. Үүний хүрээнд Сангийн яамны зүгээс жил болгон төсөв болон төлбөрийн тэнцэл дээр хийлгэх гадаад валютын дарамтыг, төсвийн дарамтыг бууруулах үүднээс өрийн зохицуулалтын арга хэмжээг байнга авч

хэрэгжүүлж байна. Энэ жил бол 2026 оны 2 дугаар сараас 3 дугаар сарын эх хүртэл сөнчри 5 өрийн зохицуулалтын арга хэмжээнд 2026 болон 2028 онд төлөгдөх нийт 500 сая ам.долларын гадаад бондын өрийн зохицуулалтыг хийсэн. Ээнэ шинээр гаргасан бонд 6 жилийн хугацаатай 5.95 хувийн хүүтэй ингэж арилжаалагдсан байгаа. Тэгэхээр олон улсын зах зээл дээр яг нөхцөл байдал хүндрэхээс өмнө энэ өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2026-2028 онд төлөгдөх гадаад өрийн үйлчилгээний дарамтыг бууруулж чадсан. Яг энэ зээлийн хувьд бол нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлээр хэрэгжиж байгаа. 5 жилийн хугацаанд үндсэн төлбөр төлөгдөхгүй. 2030-2055 он хүртэл үндсэн төлбөр төлөгдөх төсөв дээр ирэх дарамт бол ийм бага байгаа. Ийм зээл байгаа.

Засгийн газрын өрийн нээлттэй ил тод байдал дээр бол Сангийн яамны зүгээс Засгийн газрын өрийн улирлын бүлгинийг улирал болгон Сангийн яамны вебсайт дээр тавьж байна. Үүн дээр бол агуулга нь ямар байдаг вэ гэхээр Засгийн газрын өрийн нийт үлдэгдэл, дотор нь өрийн хэрэгслээрээ үлдэгдэл Засгийн газрын гадаад зээлээр эзэмшигчийн байдал, Засгийн газрын нийт өрийн багцын жигнэсэн дундаж хүү, жигнэсэн дундаж хугацаа. Үүн дээр нэмээд бас Засгийн газрын өрөөс гадна улсын секторын өр буюу ТӨК-ийн өр төлбөрийн үлдэгдэл, төсөв дээр учирч болзошгүй дарамтууд, Засгийн газрын гадаад болон дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн өгөөжийн мэдээлэл зэрэг ийм мэдээллүүдийг багтаасан мэдээллийг олон нийтэд байнга ил тод нээлттэй тавьж байгаа.

Яг энэ зээлийн хэлэлцээрийн хувьд бол эргэн төлөлтийн хувиар нь зээлийн хэлэлцээр дотроо бүрэн тусгагдсан. Энэ маань болохоор ди парламент дээр олон нийт дээр ил тод тавигдаад эргэн төлөлтийн хуваарь ди парламент дээр тавигдаж ингэж явж байгаа.

Н.Наранбаатар: Тэмүүлэн гишүүн тодруулъя.

Г.Тэмүүлэн: Үгүй яах вэ хариуцлагатай хандах асуудал дээр л бид нар энэ сахилга бат хариуцлагын асуудлыг л асуугаад байгаа юм. Энэ өр зээлийн асуудлууд дээр тодорхой хязгаарлах асуудлууд дээрээ бид нар хариуцлагатай хандах л ёстой. Тэгээд би тодорхой юм асууж байгаа нь Өрийн удирдлагын тухай хуулийн 6.5.4-ийг энэ зээлийн хэлэлцээрийг оруулж ирэх бүрдээ та бүхэн нийт юу гэдэг юм зээлийнхээ хэмжээ эргэн төлөх хуваарь жингэнэсэн дундаж хүүнд хэрхэн нөлөөлж байгаа юм гэдэг нөлөөллүүдээ та бүхэн олон нийтэд танилцуулчих ёстой байхгүй юу. Тэгээд тэрийгээ яг яаж хэдний өдрийнхөөр хэвлэлийн хурлаар гэдэг юм уу олон нийтэд яаж мэдээлсэн юм бэ? Энэ бол цэвэр үндсэндээ бид нар тэр 2023 оны 5 сард хийсэн төсвийн хариуцлагатай холбоотой хуулийн хүрээнд ингэж зохицуулалтуудыг хийж хариуцлагыг өндөрсгөсөн босгож шалгуурыг нь дээшлүүлсэн асуудлууд байгаа. Тэгэхээр бид нар хүсэж байгаа зүйл нь та бүхэн хариуцлагатай хандаач, оруулж ирэх бүрдээ олон нийтэд энийгээ мэдээлдэг байгаач гэдэг асуудлыг л хөндөж тавиад байгаа юм. Эсвэл тэр зүйлийгээ хийгээгүй бол хийгээгүй гэдгээ хэлээд.

Н.Наранбаатар: 6 номер хариулъя.

Л.Гантогтох: Сангийн яамны өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох. Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя.

Зээлийн хэлэлцээрийг Засгийн газар болон Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхдээ Сангийн яамны зүгээс өр дээр яаж нөлөөлөх юм өрийн үйлчилгээн

дээр яаж нөлөөлөх юм гэдэг энэ мэдээллийг тогтмол танилцуулаад тусгаад энэ нь болохоор Улсын Их Хурал болон Засгийн газрын холбогдох олон нийтэд тавигддаг ди парламент веб сайт дээр тавигдаж ингэж олон нийтэд тогтмол мэдээлэгдэж байгаа. Эрчим хүч-4 төслийн хүрээнд бол нийт 78 сая долларын зээл. Үүнээс хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж бол 0.25 хувийн хүүтэй. Үүнд нь яг тооцох юм бол 678 мянган ам.долларыг нийт зээлийн хэрэгжилтийн хугацаанд төлөхөөр байгаа. Мөн зээлийн нэг удаагийн шимтгэлийг төлөхөөр байгаа. Энэ нь мөн 0.25 хувь. Энэ нь нийт 195 мянган ам.долларын төлбөрийг төлөхөөр байгаа.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Тэмүүлэн гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Батжаргал: Зээлийн хэлэлцээрийг дэмжье. Тэгэхдээ бид энэ гадаадын зээлийг олон жил авч ашиглаж байгаа улсууд. Энэ зээлийн хэлэлцээрийн ерөнхий заалтууд дотор бас анхаармаар юмнууд байгаад байгаа. Одоо жишээ нь тэр Солонгосын Эксим банкны 10 аймгийн дулааны станц барих зээлийн хэлэлцээр дээр манайхаас үл хамаараад өөрсдийнх нь сонгон шалгаруулсан компани дампуураад дуусаагүй үйлдвэрлэлд зөндөө зээл авчхаад байгаа юм. Тэрний хүүгийн төлбөрийг бид төлөх юм уу, эс үгүй бол тэр гүйцэтгэгчээ сонгон шалгаруулж байгаа олон улсын санхүүгийн байгууллага эс үгүй бол тухайн тэр зээл олгож байгаа улс орны банк санхүүгийн байгууллага нь түлхүүр гардуулж өгөх ёстой юм уу? Тэр хооронд үүсэж байгаа харилцаагаа өөрсдөө даах ёстой юм биш үү?

Ер нь энэ цаашид энэ зээлийн хэлэлцээрт энэ асуудлыг их тодорхой болгож оруулахгүй бол боломгүй байгаад байгаа юм аа. Энэ хэлэлцээр дотор чинь тийм утга санаатай тодотгосон зохицуулалт орох бололцоо бий юу? Энийгээ бодоорой гэдгийг зориуд нэг хэлмээр байна. Мэдээж сонгон шалгаруулалт гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил явагдана. Та бүхэн юу төсөл хэрэгжих буюу бүтээн байгуулалтын ажлыг 1.5 жил байх юм уу гэж ингэж тооцож байгаа юм байна. Тэгээд үндсэндээ 2028 оны эхний хагаст багтаж ашиглалтад орох юм гэж тооцож байна. Гэтэл бид төсөл хэрэгжих хугацаагаа 5 жил гээд хэлчихсэн. Цаад санхүүгийн байгууллагаас авч байгаа эх үүсвэрийг чинь хуваарилалтын график наад хийж чадах ажлынхаа цаг хугацаатай уялдвал их зохицолтой. 5 жил гээд хэлчихдэг өөрсдөө бид 1.5 жилд хийж гүйцэтгэж чадна гэж үзэж байгаа бол тэр рүүгээ дөхүүлж авах тийм уян хатан графикайн тохирлоо хийхгүй боломгүй ээ. Энийгээ нэг бодмоор байна.

3 дахь миний хэлчихмээр байгаа санаа гадаадын зээлүүдийг үнэхээрийн нэн шаардлагатай чиглэлүүдээр нэн хөнгөлөлттэй нөхцөлөөр авч байна гээд л хэдүүлээ аваад л байгаа үнэндээ. Тэгэхээр эрэмбэ дараа тогтоохгүй болохгүй байна аа. Энэ улс орны эдийн засгийг дэмждэг суурь салбар дээрээ эс үгүй бол энэ улс орны эдийн засгийг тэлэлт идэвхжилтэд томоохон хувь нэмэр оруулдаг энэ иргэдийн амьдралын чанарт бас гайгүй дэм үзүүлчихээр өөрөө өөрийнхөө үйл ажиллагаагаар бас анхны өртөг зардлаа богино хугацаанд нөхчөж болохоор энэ тэр ийм чиглэлүүдээр зээл авах асуудлыг хиймээр байгаа юм.

Тэгэхээр одоо явж байгаа энэ зээлүүдийг нэг эрэмбэлж харж тогтоох тухай асуудал байна гэж.

Хоёрдугаарт одоо энэний өмнө яригдлаа. Тэр зээлийн ашиглалт үр өгөөжийг сайжруулах тухай асуудал үнэхээрийн тийм өөрийнхөө үйл ажиллагаагаар анхны хөрөнгөө нөхчхөж болох тийм чиглэл төсөл дээр зээл авч байгаа бол тэрийгээ өрийн удирдлагын тухай хуулийнхаа Засгийн газрын өрийн хэмжээндээ багтаагаад тэгээд санхүүжих үйл явц нь энэ Хөгжлийн банк энэ тэрээ ашигладаг энэ юм руугаа ормоор байна аа. Тэгэхээр 1 ганц үндсэн заалт оруулж ирээд байх юм. Тэр Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль тэр бүртгэлийн тухай хууль гээд энэ бүх хуулиуддаа тэр юмаа шигтгэж оруулж хууль хоорондын уялдаа юмнуудыг нь хангадаг барьдаг юмаа шийдэхгүй бол болохгүй ээ. Тэгээд одоо бид хэд Төсвийн тогтвортой байдлын хуулиа ярьцгаагаад хэдүүлээ 1.7 тэрбум долларын зээл шийдэгдчихээд ажлынх нь ихэнх явчхаад байхад үлдэгдэл санхүүжилтээ авахад.

Н.Наранбаатар: Наранбаяр гишүүн үг хэлнэ.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ төслийг дэмжиж байгаа.

Яагаад гэвэл энэ бол үндэсний аюулгүй байдалтай холбоотой эрчим хүчний бодлогыг ялангуяа төвийн бүсийн эрчим хүчний өнөөгийн нөхцөл байдлыг эрс сайжруулахад хэрэгтэй гэж харж байгаа. Өнөөдөр төвийн бүсэд нийт дэд станцын тоног төхөөрөмжийг 30-аас 40 жил ашиглачихсан хэзээ ч эвдрэхэд бэлэн цахилгаанаар доголдоход ийм бэлэн болчихсон ийм нөхцөл байдалд энэ нүдээ олж орж ирж байна гэж харж байна.

Арвайхээр дэд станц Баянхонгор аймгийн Баянхонгор суманд байрлах дэд станц, Дундговь аймгийн Сайнцагаан суманд байрлах Мандал дэд станц гээд нийтдээ нэг 78 сая долларын ийм хөнгөлөлттэй зээлийг авах юм байна. Эргэн төлөлтийг нь харахад 2030-2055 оны хооронд жил болгон 1-ээс бараг 4 хүртэл хувийн хүүтэйгээр ингээд төлөөд явна гэж ингэж ойлголоо. Тэгэхээр энэ дээр бас энэ төслийг хэрэгжүүлэхдээ бас өмнөх энэ манай Улсын Их Хурлын гишүүд хэлээд байгаа тэр асуудлыг бас сайн бид эргэж харж энэ сургамжийг үзэх ёстой гэж бодож байгаа. Тэр ДЦС-тай холбоотой Солонгосын Эксим банкнаас авсан зээл үндсэндээ дампуурчихлаа шүү дээ. Гэрээгээ л маш муу хийсэн гэсэн үг шүү дээ. Гэрээгээ маш муу хийсэн. Цаад талаасаа бүх сонгон шалгаруулах эрхийг нь цаад талд нь өгчихсөн. Тэгээд тэрийг цаад тал нь өөрсдийнхөө дүрмээр хийхдээ дампуурах ААН-д өгөөд ингээд дампуураад дампуурсан энэ ААН нь ажлаа хийхгүй ингээд хэн хохирч байгаа юм Монгол Улс өртэй л үлдэж байна. Өөр юу ч байхгүй. Дутуу барьчихсан баахан станцуудтай. Дөнгөж ийм суурийг нь тавьчихсан ийм баахан балгасуудтай л үлдэж байгаа байхгүй юу. Тэр зээлийг шингээх чадвар, үр ашигтай ашиглах чадвар.

Энэ дээрээ та бүхэн анхаарч ажиллах шаардлагатай гэж ингэж бодож байгаа. Тэгэхээрээ энэ эрчим хүчний энэ зээлүүд бол ер нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг бий болгох ийм маш чухал. Тэгээд хөдөөгийн амьдралын чанарыг дээшлүүлэх хамгийн чухал ийм төслүүд учраас бид бол дэмжээд явах ёстой гэж харж байгаа. Харин гагцхүү энэ сургамжийг бас та бүхэн авч ашиглаж энэ сургамжаасаа бас дүгнэлт хийж энэ зээлийг цаг хугацаанд нь ашиглаж ингэж явах ёстой гэж бодож байна. Одоо 5 жил гээд яригдаж байна. Гэтэл 1.5 жил гүйцээнэ гэсэн ийм юм яригдаж байгаа бол энэ ахиад л бас буруу тооцоолол явж байна л гэсэн үг. Энэ тооцооллоо зөв болгож цаад талдаа хэлэлцээрээ хийхдээ бас энэ бодитой байдалтайгаа нийцүүлээрэй л гэж хүсэж байна. Баярлалаа.

Н.Наранбаатар: Сайнзориг гишүүн үг хэлнэ.

П.Сайнзориг: Баярлалаа. бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Би нөгөө Батжаргал дарга, Тэмүүлэн гишүүний даргын, бас хэлж байгаа зүйлүүдтэй зарчим ижил байгаа. Яах вэ яг энэ зээлийн асуудал дээр Улсын Их Хурлын гишүүн бид яг нэг ийм 2 нүүртэй байгаа юм аа. Нэг Януг гээд нэг бурхан байдаг юм шүү дээ. Грекийн бурхан. Яг 2 тал руугаа харчихдаг. Зээл ав гэдэг, авсан хойноо ашиглаж болохгүй гэдэг. Тэгээд яг л ийм нэг юман дотор яваад байдаг тэгээд энэ зээл болгон чинь өөрөө нөгөө Улсын Их Хурлаар соёрхон баталж байгаа учраас хууль байхгүй юу. Хуулиудыг бид нар хэрэгжүүлэхгүй гэдэг зүйлийг ярьж болохгүй. Тэгээд ерөөсөө ихэнх энэ авсан зээлүүд чинь цаг хугацаандаа дуусаж байгаа юм байхгүй нөгөө төсвийн тусгай шаардлага байдаг юм уу, тодорхой Төсвийн хууль бид хэд төсвийг алдагдалгүй батална, төсвийн зарлага талдаа энэ гадаад зээлийн ашиглалтын асуудлыг нь тааз тогтоочихдог. Тэгээд авсан зээл маань ашиглагдахгүй байсаар байгаад жишээ нь 10 зүйлийг барьж болох байсан бол барих хугацаандаа явсаар байгаад ч юм уу ашиглах тэр зээлийн орон зай хумигдсаар байгаад юу вэ гэхээр нэг 8 зүйл, 9 зүйлийг барьдаг ч юм уу. Яг нөгөө хүрэх ёстой үр дүндээ ерөөсөө хүрэхгүйгээр л ингээд зээлийг маш муу ашиглаж байгаа юм. Маш муу.

Сая тэгээд Батжаргал дарга нэг тод жишээг тэр газрын тосны үйлдвэр дээр ярьж байна л даа. Бид хэд зээлийг авсан нэмэлт санхүүжилтийг чинь баталгаажуулчихсан. Тэгээд яг төсөв батлахдаа эергээр нь харж байгаад үгүй шүү хоёр зуухан тэрбумыг зарна. Яг ингэжээд байхаар бид хэд ерөөсөө 1 тийм Улсын Их Хурлын гишүүд бид хэд байна шүү. Бид өөрсдөө ав гэхээд зарцуулж болохгүй гэхээд байгаа юм. Тэгээд яах вэ олон нийтэд мэдээлэл гээд Тэмүүлэн даргын хэлж байгаа зөв. Олон нийтээ бас мэдээлэлжүүлэх нь зөв. Тэгэхдээ эцсийн дүндээ яг энэ дээр цаашдаа яах вэ гэдэг бодлогыг энэ Улсын Их Хурлын гишүүд гаргаад байгаа шүү. Ялангуяа Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороо гаргаж байгаа. Хуулийн баталж өгчхөөд төсөв дээр өөр зүйл яриад байгаагаа бид хэд бас нэг анхаарах зайлшгүй шаардлага байна аа. Яг энэ Эрчим хүч-4 төслийг дэмжиж байна аа.

Төвийн эрчим хүчний системийн энэ хэрэглэгчийг бол ангиллыг зөв болгохгүй бол яг энд хөөрхий нэг хэдэн ААНБ тэр дундаа уул уурхайн ААН байгууллагууд дээр бүх ачаа яваад бусад хэрэглэгчид нь үндсэндээ жоохон ингээд л дайгдаад л явж байгаа. Тэгээд энийг бас цаашдаа аюулгүй тогтвортой болгоод явах юм энэ төвийн эрчим хүчний системийг хэд хэд бас ангилж хэрэглэгчээ хуваах байдаг юм уу? Бас их хэт нүсэр том сүлжээ байх шиг байна лээ шүү менежмент явуулахад.

Тэгэхээр би одоо яг эрчим хүчний мэргэжлийн хүн биш. Тэгэхдээ яг мэргэжлийн тайлангуудыг аваад үзэхээр энэ ААН байгууллагуудынхаа нуруун дээр энэ эрчим хүчний энэ үнэ өртөг нь явж байгаа юм байна лээ. Тэгж харагдахаар байна лээ. Тэгэхээр энэ дээр ер нь зүгээр ЭХЯ цаашдаа бас тодорхой бодлого дэвшүүлж тодорхой дорвитой зүйлүүдийг хийгээсэй гэж хүсэж байна. Ер нь эрчим хүчтэй байж байж энэ улсын эдийн засаг өргөжин тэлнэ, тогтвортой байна, ажлын байр нэмэгдэнэ. Энэ дээр бол хэн ч үгүйсгэхгүй байгаа. Тэгэхээр ер нь зүгээр энэ баталсан энэ зээл тусламжийн энэ ашиглалтыг сайжруулахад ямар ч байсан бид нар нэг зарчмаар хандмаар байна аа.

Өнөөдөр хэн ч эсэргүүцэхгүй байна шүү дээ. Бүгд дэмжиж байна, дэмжиж байна гээд байдаг. Яг төсөв батлах болохоороо бүгд эсрэг болоод явчихдаг. Тэгээд

л нэг баахан тааз тогтоож өгөөд энэн дээрээ аль төслөө яаж эрэмбэлэх вэ гэдэг л бөөн хэрүүл уруул тэгээд боломжгүй. Нөгөө гадна дотнын зээл тусламжууд нь гайхаад байгаа байхгүй юу.

Хоёрдугаарт ер нь буцалтгүй тусламж гэдэг бол ер нь эцсийн дүндээ худлаа даа. Тэгээд үнэ өртгийн хувьд явсаар байгаад ялгаагүй болдог. Тэгээд бид нарт бол мөнгө байгаа шүү дээ. Баялгийн сан гээд. Ирээдүйн өв санд ингээд хадгалчихсан мөнгө гаднын банканд маш бага хүүтэй хэвтэж л байна. Энэ дээр бас тодорхой хувийг нь дэд бүтцийн салбар луу оруулаад тэр боссон дэд бүтцийг хувьцааг нь ард түмэндээ ингээд ч юм уу тодорхой бүсүүдийн иргэдэд ингээд хувьцааг нь өгчхөж болдоггүй юм уу? Тэгээд давхар баялаг хүртэх гээд байна шүү дээ.

Тэгэхээр бид хэд ингээд зээл биш. Уг нь бид нарын дотоод нөөц бололцоо зөндөө л зүйлүүд байгаа. Зүгээр би яах вэ ийм зүйлүүдийг нэг асуулт асууж ярья гэж бодсонгүй. Тэгээд л бүгд бөөрөнхийлөөд л хариулна. Та хэдэд буруу байхгүй. Бид хэд хуулиа баталж байгаа.

Н.Наранбаатар: Тэмүүлэн гишүүн үг хэлнэ.

Г.Тэмүүлэн: Би зүгээр ерөнхий зарчмын л зүйлүүдийг хэлье дээ.

Яах вэ бид нар энэ гадаад зээл тусламжийг ер нь зүгээр хүссэнээрээ авдаг бус тодорхой магадгүй энэ системийг тогтворжуулах зорилгоор л авч зохицуулдаг байх уг нь хуулийн зохицуулалттай. Тэгээд цаашдаа энэ Засгийн газрынхаа өр болоод өрийн баталгааныхаа асуудлууд дээр гадаад зээл тусламжийнхаа асуудлууд дээр бас нэг жоохон бодлоготой байх, хариуцлагатай хандах, сахилга баттай байх зайлшгүй шаардлага бол байна аа. Энэ дээр та бүхэн бас онцгой анхаарч хандаарай гэдгийг би зүгээр тусгайлж хэлэх гэсэн юм.

Учир өөрөө юу юм гэхээр үндсэндээ бид нар түрүүн хэлээд байгаа энэ Засгийн газрын чинь өөрийнх нь өр зээл нэмэгдээд байдаг. Жилээс жилд 8.7 хувиар нэмэгдэж байгаа асуудал өөрөө бас нэлээн том аюулын харанга гэж би харж байгаа. Засгийн газрын чинь өрийн үлдэгдлээс гадна Засгийн газрын бусад өр буюу бонд өрийн баталгаа чинь жил бүр нэмэгдэж байгаа чинь хамгийн том эрсдэлтэй зүйл болоод байна аа. Энэ дээр анхаарал андуулаач ээ, энэ дээрээ хяналт тавьж чадахгүй байна. Хэрэв юу гэдэг юм тухайн тэр орон нутгийн байна уу хааныхын байна тэр нэг өрийн баталгаа гаргаж байгаа бол тэр төсөл болгон дээр нь эрсдэлийн үнэлгээг нь хийдэг байгаач ээ. Урьдчилж төлөвлөлтийг нь зөв хийдэг байгаач ээ.

Эхнээсээ зөв төлөвлөж хариуцлагатай ханддаг байгаач ээ. Эрсдэлийн үнэлгээ хийх зохицуулалтыг нь, хууль дээр нь, журам дээр нь та хэд өөрсдөө зохицуулалт оруулж өгөөд хийхгүй бол наадах чинь цоорхой хүүдий шиг ингээд нэг гардаг бас нэг ийм онгорхой нүх болчихлоо. Үндсэндээ энэ асуудлууд дээрээ бид нар бас хариуцлагатай хандахгүй бол одоо ингээд жилээс жилд хэдэн их наядаар нэмэгдүүлээд байж боломгүй болчихоод байгаа юм. Засгийн газрын чинь өрийн баталгаа 2025 онд 6.4 их наяд байсан. Бонд болоод өрийн баталгаа. Гэтэл 2026 онд 10.3 их наяд болж байгаа юм. Бараг 4 их наядаар нэмэгдэж байна шүү дээ. Тэгээд энэ дээрээ ямар ч хяналт байхгүй. Эргээд аймгууд нь ч бонд гаргадаг, гадаад зээлийнх нь хэмжээ нь ч нэмэгддэг, дотоод зээлийнх нь хэмжээ нь ч нэмэгдээд явдаг.

Эргээд нөгөө нэг өртэй хүн өөдөлдөггүй, өттэй мод таргалдаггүй гэдэг шиг ингээд ийм буруу замаар бол будаад тээгээд баймааргүй байна аа. Бид нар чинь нэг их тийм баян улс биш шүү дээ. Тэгээд л хаа хамаагүй улсад нь бусад өөр газрууд нь хэрэгцээтэй эрх ашгийн эрэмбээр магадгүй 1, 2-т шийдэгдэх ёстой асуудлууд байгаад байтал магадгүй юу гэдэг юм жил болгон л явган хүнийхээ замыг сольж байдаг бараг шинэ шахуу замаа дахиад шинэчилж байдаг, бордюруудыг нь сольж байдаг асуудлууд бол зохисгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь бол үндсэндээ Сангийн яамны чинь бодлогын гадна наад өр зээл, гадаад дотоод бонд баталгааны чинь асуудал гарчхаад байна аа.

Хэрэгцээгүй зүйлд зарцуулдаг болсон байна аа. Эргээд хүссэн хүсээгүй наадах чинь төсөв дээр өөрөө ачаалал дарамт болж орж ирээд байна л гэдэг асуудлууд байгаа. Тэгэхээр бол нэгдсэн энэ гадаад зээл тусламжийнхаа удирдлага талаасаа анхаарч үзээч, хуулийнхаа наад цоорхой, нөхөөс, үүд хаалгануудаа хаагаач гэдэг зүйлийг хэлэх гээд байгаа юм. Энэ байдлаар бол нөхцөл байдал бол сайнгүй шүү. Энэнээс гадна наад төрийн болоод орон нутгийн өмчийн компаниудын чинь өр төлбөр хэд байгаа нь мэдэгдэхгүй байгаад байна шүү дээ. Тэрийгээ Сангийн яам тооцож үзэж байгаа юм уу? Бараг багцаа зүгээр аудитын нэг дүгнэлтээр нь аваад үзэхээр өнгөрсөн онд бол 22.8 их наяд гэж гарч байсан. Би энэ тоо бол нэлээн дарсан тоо гэж харж байгаа. Магадгүй 2, 3 дахин их ч байж магадгүй. Тэгээд бид бүхний яриад байгаа наад Засгийн газрын болоод бусад өрөөс чинь гадна дахиад 40, 50 их наядын ч өр зээл энэчээ байж магадгүй болчихоод байна шүү дээ. Үндсэндээ нийт улсын чинь төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүний 40-өөс дээш хувь нь бол үндсэндээ төсөв болчихоод байдаг. ДНБ-ий чинь 43.9 хувь нь үндсэндээ Засгийн газрын энэ өр зээл түүнд төлөгдөж байгаа өрийн чинь үйлчилгээ болоод байна аа. Энэ бол хүссэн хүсээгүй төсөв санхүү эдийн засгийг бид нар салгаж ойлгож ойлгохгүй болчихоод байгаа юм.

Макро эдийн засаг дээр чинь сөргөөр нөлөөлж байна. Валютын гадагшлах урсгал дээр чинь нөлөөлж байна. Энэ бодлого дээр жоохон нэг бодлоготой, хариуцлагатай, хяналттай байх зайлшгүй шаардлага байна шүү. Энэ дээр та хэд нэг томоор нь харж наад нэг алдаа оноогоо засаж залруулах зүйл дээрээ бас нэг анхаарч ажиллаач л гэдэг зүйлийг хэлэх гэсэн юм.

Н.Наранбаатар: Ганбат гишүүн үг хэлнэ.

Д.Ганбат: Үгүй ээ одоо тэгээд энийг чинь дэмжихгүй гээд яах юм тиймээ? Дэмжиж л таарах байх л даа дэмжиж л байна л даа. Тэгээд нэг ийм байдалд оруулаад байгаа нь хэцүү байгаа юм л даа. Энэ чинь одоо ард түмэн засаглаж байгаа гээд байгаа энэ ер нь хулгайч нар л засаглаад байгаа юм биш үү энэ улс оронд чинь. Та хэдээс юуг нь асуух вэ дээ мэдээж хэрэг. Цаана нь хэдэн хулгайчууд л байж байгаа шүү дээ. Тэгээд л хараад сууж байгаа биз. Тэгээд хамгийн наад захын жишээ гэхэд энэ их олон зээлүүд чинь уул нь гаднын хөрөнгө оруулалт орж ирээд, дотоодын хөрөнгө оруулалт сайжраад ингэж л явах ёстой л доо. Хэвийн болж бүтэж байгаа улс орон бол. Тэгэхэд одоо гаднын хөрөнгө оруулалт ерөөсөө орж ирж байгаа юм алга сүүлийн жилүүдэд. Ийм олон хулгайчуудтай газар хэн ч оруулах вэ дээ мөнгөө, хөрөнгөө. Дотоодынхон бол өдөр болгон хаалгаа барьж байна. Нефтийн үйлдвэр хийж байна гээд л 8 жилийн өмнө эхэлсэн. 1.2 тэрбумд багтаана л гэсэн. Одоо 1.7 билүү 8 болчихсон л явж байгаа.

Тэгээд тэрийгээ одоо төсөвт тусгахгүй байна гэж байгаа тиймээ тэрний төлөлтийг. Тэр нь энэ гадаад зээлийн ачилт сайжраад ч байгаа юм уу, муужраад ч байгаа юм уу, муудаад ч байгаа юм уу. Тэр хүн болгон сая ярилаа тэр дулааны 10 станцыг. Ард нь ард иргэд л хохирч байгаа байхгүй юу. Зээлийн хүү явж л байна. Зээл авахынхаа өмнө та бүхэнд танилцуулаад хэзээ ямар хугацаатай төлөх юм. Энэ бүх хуулиуд нь байж л байгаа байхгүй юу. Сая манай Аюулгүй байдлын байнгын хорооны дарга ойлгомжтой хэлж байна, асууж байна энийгээ хийсэн үү гээд. Хийгээгүй л байгаа байхгүй юу даа. Нэг ийм л байдалтай яваад байгаа юм л даа.

Уул нь бид нар чинь баялагтай. Баялгаа тэр дэлхийн тэр дундаж түвшинд үнийг нь хүргээд өгчихвөл хажууд нь зах зээл нь байгаа, хангалттай л ийм улс орон шүү дээ. Юун бусдаас зээлэх бусдад зээлж байх ёстой улс орон байхгүй юу. Тэгэхэд өнөөдөр хар л даа бүгд зугтаж байна шүү дээ энэ улс орноос. Залуучууд зугтаж байна. Хэдэн хулгайчид л энэ дээр найрлаж байна л даа. Тэр гаргаж байгаа нүүрсээ хэдээр өгөөд байгаа юм бид нар. Тэр төмөр замаа яаж тавиад байгаа юм. Бүгдийг нь нууцална гэж байгаа. Удахгүй энэ бас зээллэгээ нууцлах юм байгаа биз.

Тэгээд сонсгол хийхээр хэдхэн зөв л хүмүүс дэмжиж байгаа шүү дээ. Миний хажууд сууж байгаа энэ 2 ХҮН намаас. Бас АН-аас хэдэн хүн байж байна. Ардын намаас хэдэн хүн байна. Ер нь нам хамаагүй болчихжээ. Хулгайч хулгайч бишээрээ л хуваагддаг болчихсон байна. Тэгээд энийг хэн ч ярьдаггүй. Авлигачид, хулгайчид нь нэг талдаа гарч байх шиг байна. Монгол Улсын Ерөнхийлөгч бол зөв л шаардлага тавьж байгаа шүү дээ. Тэгтэл яаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгч хуулиар бол цорын ганц нэр хүндийг нь хамгаалсан субъект шүү дээ. Бүх ард түмнээсээ сонгогдсон. Тэгэхэд энэ олон троллыг энэ олон хүмүүс хөлслөөд яаж ажиллаж байна. Өдөр шөнөгүй л хараар будах гэж оролдож байна шүү дээ. Энийг Аюулгүй байдлын байнгын хороон дээр ярих ёстой зүйл гэж бодож байгаа юм би бол. Ийм л байдалтай байна. Тэр авлига хулгайтайгаа тэмцэж байгаа нь хаана байгаа юм бэ? Эд нар чинь бүүр даам гарчихсан байна шүү дээ. Хэн ч хариуцлага хүлээхгүй байна. Хар л даа тэр Голомт банкнаас 120 саяд бишээ Эрдэнэс Монголоос гарсан гэж байгаа тэр мөнгө. Эрдэнэс Монголоос гараад Голомт банкаар дамжаад 130 сая долларыг портороор ачиж яваад саунаар өшөө хаана гэлээ? Ресторанаар тараасан гэж байгаа шүү дээ. Хариуцлагатай албан тушаалтан тэгж байгаа байхгүй юу.

Н.Наранбаатар: Эрдэнэболд гишүүн үг хэлнэ.

С.Эрдэнэболд: Зээлийн хэлэлцээрийг дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ оруулж ирж байгаа хүмүүс нэг зүйлийг анхааралдаа аваач. Өмнөх сайдад бол яг энэ асуудлыг ярьсан юм аа. Би нэг үндэсний аюулгүй байдлын мөрдөгдөж байгаа үзэл баримтлалын 3.2.1.2 дээр байгаа хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ гээд эрчим хүч гэж байгаа энэ дотор орж байгаа юм. Энэ бол олон улс, Европын холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлнэ гэсэн нэг заалт байгаа. Дараад нь 3.2.4.2 дээр эрчим хүчний дотоодын гол эх үүсвэр болох нүүрсийг, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, орон нутаг нутагт үйлдвэрлэлийг дэмжиж ажлын байраар хангах зорилгоор гэж явж байгаад 2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрээр бүрэн хангана гэж байгаа юм. Бүрэн гэдэг чинь бол 100 хувь гэсэн үг шүү дээ. 16 жилийн өмнө энэ зорилгыг тавьсан.

Одоо 2026 он. Тухайн үед Их Хурлын 48 дугаар тогтоолоор батлагдсан. Тэгэхээр энэ бодлого чинь хаана байгаа юм бэ гээд өмнөх сайдаас жишээлбэл

асуухад юу гэж хариулж байсан гэхээр хөнжлийнхөө хэрээр хөлөө жийнэ гэдэг томъёоллыг надад хэлж байсан. Өөрөөр хэлбэл нөгөө хэн сайд байгаа тэр хүний тодорхой үед гарч байгаа нөхцөл байдал асуудал бэрхшээлд л тулгуурлаад байгаа болохоос биш манай улсын бодлогын бичиг бай баримт, богино дунд хугацааны стратегийн, зорилтот энэ эрчим хүчний чинь бодлого хаана явж байгаа юм бэ гэдгээ бид нар тодорхой болгож чадахгүй яваад байгаа юм. Ингээд энэнээс үүдээд эрчим хүчний бодлого бол эзэнтэй ч юм шиг, эзэнгүй ч юм шиг 2-ын хооронд яваад байгаа юм. Тэгэхээр одоо энэ 78 сая доллар гэдэг маань нийт манай улсын эрчим хүчний бие даасан тусгаар тогтнолоо хангасан үндэсний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхад шаардлагатай төсвийн хэчнээн хувь нь орж ирж байгаа юм. Энд яг одоо та нарын тооцоо симуляц ямар байгаа юм.

Дахиад ямар хэмжээний эх үүсвэр байж байж ямар хэмжээний магадгүй төсвийн болон төсвийн бус хувийн хэвшилтэйгээ хамтарсан орлогын сурвалжууд байж байж бид нар энэ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дээр байгаа энэ зорилтоо хангах юм? Нэгдүгээр зүйл байгаа. Энийг та нар бодолцож үзээсэй. Энэ бол асуулт биш үг учраас хэлж байгаа юм.

Хоёрдугаарт нь гэх юм бол ер нь одоо энэ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг сураг сонсох нь ээ. Нэг нь яг ийм зорилтын шинж чанартай буюу тунхгийн шинж чанартай, нөгөөдөх нь болох юм бол яг цаг хугацаатай, хэмжих нэгжтэй, он сартай ийм зорилт болж орж ирээд ингээд хуваагдаж орж ирэх юм гэсэн. Тэгэхээр ер нь бол яг энэ нэг удаагийн зээлийн асуудал биш цаашдаа бид нар яг энэ бодлогыг яаж авч үзэх юм бэ? Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр ч гэсэн яг энэ бодлогыг татаж авчраад энэ бусад салбаруудтай гадаадын зээл тусламжтайгаа уялдаа холбоог нь хангах чиглэлээр хаалттай ч байна уу ойлголцлын энэ долгион тааруулах зүйл хийхгүй бол одоо ингээд л өмнө нь Европын сэргээн босголтын банкнаас зүрхний эмнэлэг байгуулна ийм зээл хэрэгтэй, эрүүл мэнд учраас бид нар дэмжчихдэг. Боловсрол учраас дэмжчихдэг. Эрчим учраас учраас дэмжчихдэг. Онцгой шаардлагатай гээд дэмжчихдэг. Гэхдээ энэ бүхний чинь цаана нэг том зургаараа үзвэр байх ёстой шүү дээ дүгнэлт байх ёстой шүү дээ. Энэ дээр яг одоо энэ Найдалаа сайд, эрчим хүчний бодлого гаргаж байгаа хүмүүс Улсын Их Хуралд манай энэ Байнгын хороонд яг тодорхой мэдээлэл өгөөч ээ.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд асуудал шийдэх гээд байгаа юм уу эс үгүй бол тухайн бодлогын салбарын нөхцөл байдал саад бэрхшээлд тохируулж асуудлаа шийдэх гээд байгаа юм уу? Өмнөх сайдын баримталж байсан хөнжлийнхөө хэрээр хөлөө жий гэсэн хариултыг бид нар бодлого гэж авах юм уу? Эс үгүй бол энийг цаг хугацаа гал унтраах аргачлал гэж авах юм уу? Энэ дээр тодорхой ойлголтууд дүгнэлтүүд хэрэгтэй байна гэдэг саналыг хэлье.

Н.Наранбаатар: Баярлалаа. Мөнхсоёл гишүүн үг хэлнэ.

Б.Мөнхсоёл: Сайн байцгаана уу? Тэгэхээр энэ нөгөө өмнө нь яг хэлэлцсэн нөгөө Гадаад зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл дээр хэлсэн асуудлууд яг одоо хэлэгдэнэ л дээ. Өөрөөр хэлэх юм бол өмнөх гишүүд маань бас хэлээд байна шүү дээ. Өмнөх 4 жилийн хугацаанд бас Төсвийн байнгын хорооны дарга байсан Тэмүүлэн гишүүн бас хэлж байна. Энэ төсвийн сахилга баттай холбоотой асуудал байгаад байгаа юм аа. Тэгээд Эрдэнэболд гишүүний хэлсэнчлэн бас эрчим хүчнийхээ салбарын асуудлуудыг шийдмээр байна. Бусад

салбар салбарын сайд нар өөр өөрсдийнхөө асуудлыг шийдэх гээд ороод ирдэг. Гэтэл нөгөө талдаа гадаад зээлийн асуудлуудыг шийдэхээр Төсвийн тогтвортой байдлын хуульдаа байгаа төсвийн дүрмүүдээ зөрчихөөд байгаа юм. Тэгэхээр энийг бүгдээрээ мянган удаа ярьж байна. ДНБ-тэй харьцуулсан өрийн хэмжээ, ДНБ-тэй харьцуулсан төсвийн алдагдлын хэмжээ гээд тэгээд бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Өрийг өрөөр дарсаар яваа шүү дээ бид нар нөгөө хүссэн хэмжээндээ хүрээгүй байгаа. Энэ олон асуудлуудыг яаж шийдэх вэ? Бусад гишүүдийн хэлээд байгаа нэг талдаа дэмжээд нөгөө талдаа үгүйсгээд ингээд нэг бид нар ч гэсэн өөрсдөө эргээд гацалтын байдалтай алийг нь дэмжих гэхээр нөгөөдөх нь хаягдчих гээд иймэрхүү байдалтай байна шүү.

Тэгэхээр 1 зүйлийг мэдээлэл болгоод хэлчихье. Сангийн яаман дээр яригдаж байгаа боловсруулагдаж байгаа Хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төсөл боловсруулагдаж байгаа. Бараг дуусах шатдаа явж байгаа. Энэ хуулиар юу шийдэх гээд байгаа вэ гэхээр яг энэ төсвийн сахилга бат гэдгийг хадгалах гээд байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол аливаа төслүүдийг хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх эх үүсвэр нь чухал байна. Эрэмбэлье хөрөнгө оруулалтын төслүүдээ улсын төсвөөрөө аль хөрөнгө оруулалтаа хийх юм. Гадаадын зээл тусламжаар алийг нь хэрэгжүүлэх юм орон нутгийн төсвөөр юуг хийх юм яагаад гээд. Тэгээд төслийнхөө хэмжээг бүүр бичлээс нь өгсүүлээд мега хүртэл ангилаад. Алийг нь мега гэх юм, алийг нь бичил гэх юм, алийг нь дунд хэмжээ гэх юм? Зөвхөн төсвийн хэмжээн дээр суурилах уу цар хүрээгээр нь суурилах уу гээд ийм нарийн хууль гарах гэж байгаа. Энэ бол маш чухал хууль шүү. Тэгээд ийм байдлаар шийдэхгүй бол бүгдээрээ түр зуурын байдалтай үүрдийн бус шийдвэр. Дараа нь эргээд шийдсэн юмныхаа эсрэг дахиж асуудалд орох ийм байдлууд үргэлжилсээр байна аа.

Тэгээд нэмээд төсвийн сахилга батаас гадна нэмж хэлэх нэг зүйл юу вэ гэхээр ерөөсөө нөгөө төлөвлөлт тооцоолол байгаа юм. Энэ анхнаасаа төлөвлөлт, төсвийн тооцоолол энэ тэр нь дутуу буруу явчихаар дараа нь гүйцэтгэлийн үнэлгээ дандаа буруу гардаг.

Тэгээд бид нар жил болгон хагас жил болгон нэг төрлийн шүүмжээ хэлдэг, асуултаа асуудаг, хариулт сонссон болдог. Ийм байдалд нэг чөтгөрийн тойрог гэж хэлдэг шүү дээ. Тиймэрхүү байдалд манай энэ шийдвэр гаргах түвшинд яваад байна шүү гэдгийг л зориуд бас протоколд үлдээхээр хэлчихье ээ.

Төсвийн сахилга бат чухал гэдгийг хаа хаанаа ухамсарлах үүднээс саяын хуулийн төсөл орж ирнэ шүү. Баярлалаа.

Н.Наранбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Санал хураалт явуулж эхэлье.

Монгол Улс, Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын Эрчим хүч-4 төслийн Зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

31 гишүүнээс 17 гишүүн дэмжиж, 54.8 хувиар дэмжигдлээ.

Лүндэг гишүүнийг дэмжсэнээр авъя.

Наранбаяр гишүүнийг, Б.Энхбаяр гишүүн, Булгантуяа гишүүн дэмжсэнээр авъя. Төхөөрөмж ажиллаагүй байна.

Уг асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн болон Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлнэ.

Монгол Улс Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын эрчим хүч-4 төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

15.08 цагт

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улс Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын Зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн Цахилгаан дамжуулах түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийн төсөл

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнууд хэвээрээ. Түрүүн танилцуулсан.

Монгол Улс ХБНГУ-ын Сэргээн босголтын Зээлийн банк хоорондын төвийн бүсийн цахилгаан дамжуулалт түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III дугаар үе шатын зээлийн болон Төслийн хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна аа. Мэндсайхан гишүүнийг урьж байна.

З.Мэндсайхан: Аюулгүй байдлын байнгын хорооны дарга, Төсвийн байнгын хорооны дарга болон Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Төвийн бүсийн цахилгаан дамжуулах түгээх сүлжээний эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төсөл нь шинэ сэргэлтийн бодлого Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан өндөр ач холбогдолтой төсөл бөгөөд тус төслийг Холбооны Бүгд Нрайрамдах Герман улсын Сэргээн босголтын зээлийн банкны эх үүсвэрээс санхүүжүүлэхээр зээлийн хэлэлцээрийг хийгээд байна аа. Энэхүү төслийг Германы сэргээн босголтын зээлийн банкнаас олгох 17 сая еврогийн зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх бөгөөд эргэн төлөх хугацаа 30 жил, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 10 жил, жилийн 2 хувийн хүүтэй нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл болно оо.

Тус зээлийн хэлэлцээр нь олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Монгол Улсын Их Хурлаар заавал соёрхон батлагдах гэрээ бөгөөд зээлийн хөрөнгийн эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр ЦДҮС ТӨХК-д дамжуулан зээлдүүлэхээр төлөвлөсөн. Төслийн хүрээнд СБД-ийн 1 дүгээр хороонд шинээр дэд станц хос цахилгаан дамжуулах кабель шугам барьж одоо байгаа Туул дэд станцыг өргөтгөх ажлыг гүйцэтгэх бөгөөд ингэснээр хотын төвийн Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хануул

болон БЗД-ийн 5 дүүргийн 14 хорооны 1 дүгээр зэргийн хэрэглэгчид болох Улсын 1 дүгээр төв эмнэлэг, 2 дугаар төв эмнэлэг Өргөө амаржих газар зэрэг нийт 11 мянган хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагаа дээшилж иргэн болон ААН-үүдийг эрчим хүчээр тогтвортой хангах ач холбогдолтой юм аа.

Иймд Монгол Улс Германы Сэргээн босголтын Зээлийн банк хоорондын Төвийн бүсийн Цахилгаан дамжуулах түгээх сүлжээний эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шатын зээлийн хэлэлцээрийг хэлэлцэн дэмжихийг хүсье ээ.

Н.Наранбаатар: Мэндсайхан сайдад баярлалаа.

З.Мэндсайхан: Зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Очирбат танилцуулна. Очирбат гишүүнийг урьж байна.

Г.Очирбат: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улс ХБНГУ-ын Сэргээн босголтын Зээлийн банк хоорондын Төвийн бүсийн цахилгаан дамжуулах түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн 3 дугаар үе шатын зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийг 2026 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдаанаараа дээрх зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Төсөл санаачлагчийн зүгээс энэхүү хэлэлцээр Улаанбаатар хотын төв хэсгийн 50 гаруй мянган хэрэглэгч болон Төрийн ордон улсын төв эмнэлгүүдийн эрчим хүчний найдвартай байдлыг хангах зорилгоор Германы сэргээн босголтын зээлийн банкны 17 сая еврогийн хөнгөлөлттэй санхүүжилтээр сүүлийн үеийн технологи бүхий 110квт-ын хаалттай дэд станцыг 2026 оноос 2028 онд барьж байгуулахаар тусгажээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд төслийн зөвлөх үйлчилгээнд зарцуулах төсөв төслийн үр ашгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл эрчим хүчний системийн найдвартай байдлыг хангах бодит шийдэл төлөвлөгөөний талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат иргэд 20квт хүртэлх нарны станцаар үйлдвэрлэсэн эрчим хүчнийхээ төлбөрийг бодитоор авч чадахгүй байгаа эсэх, иргэд ААН-ийн эрчим хүчний нийлүүлэх тарифын зөрөөний талаар. Мөн Улсын Их Хурлын 2025 оны 119 дүгээр тогтоолын хэрэгжилт, эрчим хүчний салбарын либералчлалын талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж төсөл хэрэгжих байршил болон сонгон шалгаруулалтын талаар тус тус асуулт асууж хариулт авсан болно оо.

Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд асуулт асууж, хариулт авч дууссаны дараа Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд зээлийн хүү бага боловч төслийн шугам, дэд бүтэц, зөвлөх үйлчилгээ зэрэг бодит төслийн өртөг хэт өндөр байгаа талаар, Улсын Их Хурлын

гишүүн Х.Булгантуяа төслийн дагалдах зардлуудаас шалтгаалан нийт өртөг өндөр байгаа. Мөн төслийн үр шим зардлын хяналтыг сайжруулах шаардлагатай бөгөөд цаашид олон улсын зээлийн эргэн төлөлтийг татвар төлөгчдийн мөнгөөр биш тухайн төслийг санхүүжүүлэх салбар болон ТӨК-уд өөрсдийн орлогоор хариуцах, санхүүгийн сахилга бат, төлөвлөлт хийх талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж төслийн зөвлөх үйлчилгээний зардлын дүн үндэслэл шаардлагын талаар тус тус санал авсан болно оо.

Монгол улс ХБНГУ-ын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн 3 дугаар III үе шатын зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх талаар санал хураалт явуулахад Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс ХБНГУ Сэргээн босголтын Зээлийн банк хоорондын төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шатын зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийн зөвшилцөх тухай Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Н.Наранбаатар: Баярлалаа. Зээлийн болон төслийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Ганбат гишүүнээр тасаллаа. Энхнасан гишүүн асуулт асууна.

Л.Энхнасан: Өдрийн мэнд. Нэг асуулт байна аа. Гэрээний 10.6 дээр заасан маргаан шийдвэрлэх байгууллагыг нөгөө зээлдүүлэгч талын арбитрын шүүх болох Франкфурт хот гэснийг энэ гуравдагч улсын арбитр болгож солих саналтай байна. Яагаад ингэж байна гэхлээр энэ олон улсад арбитр нь гуравдагч улс буюу гэрээний талуудын улсыг арбитраар бол ер нь сонгохоос татгалздаг. Тэгэхээр яагаад энэ дээр нөгөө манайх, манай ажлын хэсэг гэх юм уу яам ажиллаагүй байн? Ер нь бол жишээлбэл энэ арбитрыг Сингапур юм уу Лондон бас байж болохоор байсан. Энэ дээр.

Н.Наранбаатар: Хариулъя. Хэдэн номер вэ? 6 номер.

Л.Гантогтох: Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох. Энхнасан гишүүний асуултад хариулъя.

Зээлийн гэрээний 10.5 дахь заалт дээр 10.6 дахь заалт дээр энэ арбитрай холбоотой заалт байгаа. Арбитрын ажиллагаа бол Франкфурт хотод явагдана. Арбитрын ажиллагаа ангилал дээр хийгдэнэ гээд. Мөн арбитрын шүүх нь нэг эсвэл 3 томилогдсон арбитраас бүрдэнэ гэсэн иймэрхүү заалтуудыг бол гэрээний 10.6 дахь заалтад заасан байгаа. KFW банкны зээлийн хэлэлцээр бол 1990 оноос хойш бол Германаас хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг манай улс авч ашиглаж байгаа. KPW банк буюу Сэргээн босголт зээлийн банкны зүгээс бол яг зээлийн гэрээний үндсэн цаанаасаа тавигдаж байгаа шаардлагууд байдаг. Тэгээд яг зээлийн гэрээний тавигдаж байгаа шаардлагууд буюу өмнөх байгуулагдсан зээлийн гэрээнүүд дээр ч

гэсэн яг арбитраж Герман улсын нутаг дэвсгэр дээр явуулахаар ийм заалт д орсон байгаа.

Тэгэхээр энэний талаар бол манай зүгээс хүсэлт тавьдаг зээлдүүлэгч талын зүгээс бол яг өмнөх явдаг стандартын дагуу бусад улсууд ч гэсэн байгуулдаг зээлийн гэрээний үндсэн энэ тавигддаг стандарт нь бол энэ Франкфурт хотод арбитраж ажиллагаа явуулах ёстой гэдэг ийм заалт байдаг. Үүний дагуу гэрэн дээр энэ заалт орсон байгаа.

Н.Наранбаатар: Тодруулах уу? Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Бас л ахиад л зээл юм байна тиймээ.

Үгүй ээ энэийгээ жоохон өөр маягаар цаашдаа ер нь шийдэж байж болдоггүй юм уу? Хувийн хэвшлийн оролцоо хувийн компаниуд орох, хөрөнгө оруулалт хийхдээ тэр талаас нь хандаж байгаа ийм юм байдаг юм уу, байдаггүй юм уу? Миний ойлгож байгаагаар төр баахан зээл аваад л, төр л баахан юм хийгээд байна гэдэг. Тэгээд найдвартай байдал нь ямар байгаа юм бэ? Хэрвээ төр хийж байгаа юм бол энэ суурь үнэ болох энэ эрчим хүчний үнэ чинь яагаад өсөөд байгаа юм бэ? Ард иргэдийн амьдрал хүнд байхад л дурын сайд нь гарч ирээд л дурын хүмүүс нь гарч ирээд л хэлэх юм. Нэмнэ л гэх юм. Тэгээд яагаад тэр авлига, хулгай энэ юмтайгаа тэмцдэггүй юм. Тэр алдагдалтайгаа тэмцдэггүй юм. Тэгсэн мөртөө л иргэд дээрээ ачааг үүрүүлээд байх юм. Ингэж л явж ирлээ. Миний мэдэхийн тэр 4 дүгээр цахилгаан станц дээр тэр турбиныг нь солино гээд 800 сая долларын зээл авч л байсан.

Тэгээд одоо энэ эрчим хүчний найдвартай байдал чинь ямар байгаа юм бэ? хувийн хэвшил хийж байна гээд ганц нэг газрууд байгаа. Тэр Тосонцэнгэл энэ тэрд өөрийнхөө яг хувийн хэвшил хийж чадаж байх шиг байна. Энэ Бөөрөлжүүтийн станц яг хувийн хэвшил хийж байгаа юм уу? Тэр нийслэлийн бондоор л хийж байна шүү дээ. Тэр төмөр замаас авсан мөнгөний зөрөөгөөр л гэж байна шүү дээ. Тэр түрүүн дурдагдаад байгаа тэр голомтоор дамжиж баахан мөнгө угаадаг ийм юмнууд байна аа. Тэгээд эрчим хүчний нэг үнийг зориуд цаанаасаа нэмдэг тултал нь. Ард иргэд энэ чинь сөхөрч байна шүү дээ. Хэрэв улс энэийгээ бариад төр хийж байгаа юм тэрүүгээрээ яв л даа. Энэ үнээ хямдхан байлга л даа. Уул нь манайх чинь эрчим хүч импортлох биш экспортолж байхад л орно шүү дээ. Тэгээд 2 жил тэр Доржханд юм яриад л яваад байсан. Хөрөнгө оруулалт орж ирж байна энээ тэрээ гээд л хаана байгаа юм тэр чинь одоо. Нөгөө салхины сэргээгдэх эрчим хүч энэ тэр сайхан болчихлоо л гээд байсан. Тэрийг нь хааж боогоод байдаг юм уу яагаад байдаг юм. Энэ юм чинь нэг л болохгүй байна шүү дээ. Арай өөр маягаар хандаж байгаа хариуцлага ярьж байгаа ийм юм байна уу эсвэл яах юм. Одоо энэ зээлийн хүү энэ бүх юмнуудаа дараа нь үнийг нь нэмж ард иргэдээрээ үүрүүлэх үү? Тэр төртэй нийлсэн хэдэн нөхдүүдийн эрх ашгийн үүднээс тэд нарыг ашигтай байлгах ачааг ингэж үүрүүлж явах уу? Өнгөрсөн он шиг цахилгаан гэрэл нь ирэх жилүүдэд тасрах уу? Ямар байх юм? Тэрийгээ нэг хэлчих, хэлчих хүн байна уу энд?

Н.Наранбаатар: 2 номер ТНБД.

Б.Ерэн-Өлзий: ЭХЯ-ны ТНБД Ерэн-Өлзий Ганбат гишүүний асуултад хариулъя. 2025 оны гүйцэтгэлээр цахилгаан эрчим хүчний өртгийн бүтцийг авч үзвэл нийт эх үүсвэрийн өртөг нь 192 төгрөг, дамжуулах түгээх зардал 92 төгрөг

байгаа. Өөрөөр хэлбэл нэгж цахилгааны өртөг 284 төгрөгөөр үйлдвэрлэгдэж гарч байна аа. Үүнийг борлуулж хэрэглэгчдэд борлуулж байгаа тариф дунджаар 279 төгрөг байгаа. Дулааны эрчим хүчний өртөг болохоор үйлдвэрлэлийн өртөг нь нэг гикал цаг нь 32 мянган төгрөг, дамжуулалт, түгээлт зардал нь 20 мянган төгрөг, шугамын алдагдал 12 мянга гээд. Нийтдээ 64 мянган төгрөгөөр дулаан хэрэглэгчид очиж байгаа. Борлуулж байгаа дундаж өртөг 35 мянган төгрөг байгаа. Тэгэхээр үнэ өртөг бол 2024 оны 11 сард зөвхөн цахилгааны тарифыг өртөгт нь дөхүүлэх ийм шийдвэр гарсан. Дулааны тариф бол 2025 оны 7 сараас нэмэгдэнэ гэсэн энэ асуудал хэрэгжээгүй. 2024 оны 11 сараас хойш ямар нэг эрчим хүчний үнэ тариф бол нэмэгдээгүй байгаа.

Тосонцэнгэлийн, Бөөрөлжүүтийн гээд хувийн хэвшлийн цахилгаан станцууд эрчим хүчний салбарт хувийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орж ирж байна. Хувийн станцууд бол яг зах зээлийнх нь өртгөөр эрчим хүчний сүлжээнд бүтээгдэхүүнээ буюу цахилгаанаа нийлүүлж байгаа. Тэгэхээр энэ шинээр орж байгаа хувийн хэвшлийн станцуудыг энэ бодит өртгөөр нь худалдаж аваад ингээд явбал 2026 оны гүйцэтгэлээр урьдчилсан тооцоогоор цахилгааны өртөг 323 төгрөг болохоор тооцоолол байна аа.

Тэгэхээр гол энэ хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтуудаа дэмжихийн тулд бид нар бодит өртгөөр нь худалдаж авах шаардлагатай. Хэрэглэгчийн үнэ тарифыг бол зах зээлийнх нь энэ өртөгт нийцүүлэх бодит хэрэгцээ шаардлага байгаа. Эрчим хүчний салбарт одоо 2026 оны 1 дүгээр улирал гэхэд бол богино хугацаат өр төлбөр бол 600 тэрбум төгрөг болчихсон. Компаниуд дээр санхүүгийн бодит хүндрэлүүд үүсчихсэн байгаа. Тийм бодит байдал ийм байна.

Н.Наранбаатар: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Тэгээд зээл аваад л байдаг энэ эрчим хүч нь найдвартай байх юм уу үгүй юм уу? Энэ ирэх онд өвөл энэ цахилгаан дулааны үнийг нэмэх үү, яах юм гэдгийг л би асуугаад байна л даа. Тэгээд ард иргэд дээрээ энэ хулгай луйвар энэ бүх юмтайгаа тэмцэхгүй байж байж энэ бүх өртгүүдийг үүрүүлдэг тэр техник технологийг сайжруулдаггүй ийм байдалтай байгаад байна аа. Энийгээ арай өөр маягаар харж, өөр маягаар ажиллахгүй л бол энэ ард иргэдийн чинь өөрөө амьдрал нь улам дордоод, энэ ачааг чинь үүрч чадахаа байчихжээ. Энэ ААН-үүд хувийн хэвшлүүд бүгд өдрөөс өдөрт хаалгаа барьж байна. Бараг цайны газрууд хүртэл хаалгаа барьж байна шүү дээ. Ийм байдалтай байна. Гэтэл тэгээд л гарч ирсэн дурын сайд нь л цахилгааны үнийг нэмнэ, чаддагаараа тэрийг л хэлэх юм.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зээлийн болон төслийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Батболд гишүүнээр тасаллаа. Батболд гишүүн.

Р.Батболд: Зээл манай улсын маань төсвийн орлого нь тэртээ тэргүй бүтээн байгуулалтдаа хангаж хүрэхгүй байгаа учраас энэ зээлүүдийг дэмжээд байгаа юм. Тэгээд зээлүүдийг дэмжээд явахаар араас нь нэг хулгай хийсэн юмнуудаа оруулж ирээд байх юм. Энийгээ больчхооч гэдэг нэг юм ярихаар дээр нь улс төржүүлээд янз янзын юм яриад эхэлдэг боллоо. Сүүлдээ бүүр тойрог тойргийн гишүүн чи жагсаалтын гишүүнээр нь дуудаад эхэлж байх шиг байна. Энэ Булгантуяа гэдэг гишүүнээс эхлүүлээд. Ер нь бол энэ Сайнзориг гэж энэ нийслэлийн Нямбаатарын

хөхүүл хүүхэд юм уу хаашаа юм. Нэг хуулиар хулгай хийдэг, энэ хулгай хийж байгааг нь хуулиар хамгаалаад байгаа энэ хүүхдэд хэлчихэд ерөөсөө болохгүй шүү л гэж хэлмээр байна. Байгаа ард чинь байна. Тэгэхээр ер нь бол ийм байгаа юм. Зээлийн хэлэлцээрийг бид нар баталчихлаа. Тэгээд наад төсөл хөтөлбөрүүд чинь өөрсдөө ингээд яг энэндээ зарцуулаад бүтэн зарцуулаад дуусаарай гэдэг заалт арай байдаггүй болов уу л гэж би бодоод байгаа юм. Яагаад гэвэл сүүлийн үеийн зээлийн хэлэлцээрээр орж ирж байгаа төслүүд чинь өөрсдөө наад өртөг нь дэндүү өндөр гараад байна гэдэг зүйлийг л яриад байгаа юм. Энийг би Төсвийн байнгын хорооны гишүүний хувьд ярина.

2024 оноос эхлээд сонгогдсоноосоо хойш ярьж байгаад цаашид ч ярина гэж бодож байгаа. Тэгэхээр заавал энийг дуусгах хэрэг байдаг юм уу? Байхгүй наадхыг чинь хэрвээ илүү гараад байгаа бол тэрийг нь буцаагаад өгчхөж болдоггүй юм уу? Ийм асуудлаа та нар бас судалж үздэггүй юм уу гэдэг нэг асуудал байгаа юм. Яагаад дандаа энэ зээлээр орж ирж байгаа тусламжаар орж ирж байгаа энэ хөрөнгө оруулалтын зардлууд чинь төсөвт өртөг нь дандаа өндөр байгаад байдаг юм бэ?

Тэгэхээр энэн дээрээ бас та нар сайн анхаарч ажиллаач гээд Сангийн яам Эдийн засаг, хөгжлийн яамандаа хэлчихмээр байна аа.

Н.Наранбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Санал хураалт явуулъя.

Монгол улс ХБНГУ-ын Сэргээн босголтын Зээлийн банк хоорондын Төвийн бүсийн цахилгаан дамжуулах түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн 3 дугаар үе шатын зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүд санал хураалтаа бэлдсэн үү? Эхлээд санал хураалтын өмнө ирцийн санал хураалт явуулаадахъя.

Санал хураалт.

Ирцийн санал хураалтад лав 2 ороогүй. Тэгээд 13-аас 3 гээд нэмэхээр 16 гээд хүрэхгүй л байна даа. Гишүүд танхимд орж ирээрэй санал хураалт явуулах гэж байна. Байнгын хорооны гишүүд танхимд орж ирээрэй. Ажлын албаныхан гишүүд рүү яриарай дуудаарай. Бүгд дэмжиж байна.

Санал хураалт явуулна аа. Сайд нар орж ирээрэй. Сайд нар байхгүй байна. Санал хураалтад бэлдье. Батжаргал даргатай тэгээд 13 хүн л орчхоод байна. Батжаргал дарга ороогүй байна. Ганбат гишүүн ороогүй байна. Ганбат гишүүн нөгөө юундаа хуруугаа. Батжаргал гишүүн, Ж.Энхбаяр гишүүн, Наранбаяр гишүүн бэлтгэл хангах. Очирбат гишүүнийх ороогүй байна. Сая шинээр эхлүүлчихсэн. Одоо бүгд орсон байна.

Томъёоллыг уншиж танилцуулсан. Дэмжье гэдэг дээр санал хураалт.

33-аас 18 хүн дэмжиж, 54.5 хувиар дэмжигдлээ. Лүндэг гишүүнийг дэмжсэнээр аваарай, Ж.Энхбаяр гишүүнийг бас дэмжсэнээр аваарай.

Энэний дараа Аюулгүй байдлын байнгын хороо дангаараа хуралдах юм.

Уг асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлнэ. Монгол Улс ХБНГУ-ын Сэргээн босголт зээлийн банк хоорондын төвийн бүсийн Цахилгаан дамжуулах түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шатын зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Байнгын хороодын хамтарсан хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Одоо Аюулгүй байдлын байнгын хороо дангаараа хуралдана аа. Гишүүд танхимдаа үлдээрэй.

15.30 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА